

БАТЛАВ.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Г.ОНОРБАЯР

**Хүүхдийн тоглоомын талбайг барьж байгуулах, тохижуулахад тавигдах нийтлэг  
шаардлага стандартын төслийг боловсруулах ажлын удирдамж**

**Үндэслэл:**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5.2-т “Хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй”, 6.2 –т “Хүүхэд хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр эдэлнэ”, 10.1.3-т “Хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах” гэж заасны дагуу хүүхэд чөлөөт цагаараа тоглож наадах орчин болох хүүхдийн тоглоомын талбайг барьж байгуулах, тохижуулахад тавигдах нийтлэг, шаардлага стандартыг боловсруулж, батлах шаардлагатай байна.

**Зорилго:**

Улаанбаатар хотын барилга байгууламж, орон сууцны хороололд байгуулсан хүүхдийн гадаад тоглоомын талбай, байгууламжийн судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхдийн тоглоомын талбайг барьж байгуулах, тохижуулахад тавигдах нийтлэг шаардлага стандартын төслийг боловсруулах.

**Гүйцэтгэх ажлын хүрээ:**

1. Дараах чиглэлээр бичиг баримтын судалгаа хийнэ. Үүнд:
  - Хүүхдийн чиглэлээр болон бусад холбогдох хууль тогтоомжийг судлах. /Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Боловсролын тухай, Хот байгуулалтын тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, Барилгын тухай, Газрын тухай, Орон сууцны тухай, Зөрчлийн тухай, Иргэний хууль, бусад/;
  - Дээр дурдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд гарсан дүрэм, журмууд /жишээ нь: Нийслэлийн ИТХ-ын 2014 оны 166 тоот тогтоолоор “Нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөн байгуулах тухай /, стандартууд /жишээ нь: Сургуулийн өмнөх боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийн стандарт, Хүүхдийн зуслангийн стандарт г.м/;
  - НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, зөвлөмжүүд;
  - Монгол улсад хийсэн тоглоомын талбайн судалгаанууд;
2. Гадаад орны туршлага, холбогдох журам, стандартыг судлах;
3. Стандарт, журмын төслийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлж, саналыг нь тусгах.
4. Стандартын төслүүдийг ХНХЯ-ны Стандартын техникийн хорооны хурал, Стандартын үндэсний зөвлөлийн техникийн хороогоор хэлэлцүүлж, батлуулах хүртэл ХНХЯ-ны ХАХГ-ын холбогдох мэргэжилтэнтэй хамтран ажиллана.

## **Гүйцэтгэх ажил, үйлчилгээ:**

1. Хүүхдийн амрах, хөгжих, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчины талаарх хууль, эрх зүйн орчны талаарх судалгааны танилцуулга;
2. Хүүхдийн хөгжлийн, барилга байгууламж, хот тохижилтын стандарт, бусад улс оронд хүүхдийн тоглоомын талбайг барьж байгуулах, тохижуулахад баримталдаг стандарт, туршлагын талаарх судалгааны танилцуулга;
3. Улаанбаатар хотын барилга байгууламж, орон сууцны хороололд байгуулсан хүүхдийн гадаад тоглоомын талбай, байгууламжийн судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ хийж,
4. Хүүхдийн тоглоомын талбайн стандартын төсөл, танилцуулга;

## **Шалгуур үзүүлэлт:**

1. Нийгмийн ажил, гэр бүлийн чиглэлээр мэргэшсэн, чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж байсан туршлагатай, дүрэм, журам боловсруулахад оролцож байсан туршлагатай байх.
2. Нийгмийн ажлын мэргэжилтэй, магистр түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх

## **Хяналт, тайлагналт:**

1. Ажил гүйцэтгэгч нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын удирдлага, ажилтнуудтай байнга холбоотой ажиллана.
2. Хүн амын хөгжлийн газар нь ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн явц, үйл ажиллагаанд нь саад болохгүйгээр ямар ч үед хяналт тавих эрхтэй.
3. Ажлын эцсийн тайланг гэрээт ажил дууссанаас хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгнө.
5. Гадаад орны туршлага, холбогдох журам, стандартыг судлах;
6. Стандарт, журмын төслийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлж, саналыг нь тусгах.
7. Стандартын төслүүдийг ХНХЯ-ны Стандартын техникийн хорооны хурал, Стандартын үндэсний зөвлөлийн техникийн хороогоор хэлэлцүүлж, батлуулах хүртэл ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын холбогдох мэргэжилтэнтэй хамтран ажиллана.

## **Хугацаа:**

2 сарын хугацаанд дээрх ажлыг гүйцэтгэнэ.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**